



ARIG BANK



АРИГ БАНКНЫ 2017 ОНЫ ЖИЛИЙН ТАЙЛАН

ANNUAL  
REPORT

2017





- 4 Эрхэм зорилго, алсын хараа
- 6 Ариг соёл
- 8 Монгол улсын 2017 оны эдийн засгийн тойм
- 10 Банкны салбарын 2017 оны ерөнхий тойм
- 14 Аудитын тайлан
- 15 Ариг Банкны санхүүгийн үзүүлэлт 2017
- 16 Хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл
- 17 Бүтэц
- 18 Төлөөлөн удирдах зөвлөл
- 20 Манлай дэмжигчдийн нэгдэл
- 22 Компанийн засаглал
- 24 Хамт олныг халамжлах жигүүр
- 26 Мэдээлэл технологи
- 30 Нийгмийн хариуцлага
- 40 Харилцагчийг халамжлах бодлого
- 42 Эрсдэл
- 48 Харилцагчийн Өргөөдийн мэдээлэл

## ЭРХЭМ ЗОРИЛГО

Ухаан, хүсэл  
Уран сэтгэмж  
Улам шинэлэг хамт олноороо  
Уулзсан бүхний сэтгэлийг хөдөлгөх банк байна.

## АЛСЫН ХАРАА

Банкны бүтээгдэхүүн, үйлчилгээний цахим болон биет сувгийн оновчтой хослолоор харилцагчиддаа бүтээгдэхүүн үйлчилгээгээ хүргэдэг, харилцагчийн гайхалтай үйлчилгээтэй, нийгмийн хариуцлагаараа манлайлагч банк болох.

Аригчууд бидний философи маш энгийн. “Өөрийг чинь халамжилж байгаа хүмүүсийг халамжил”. Тэгвэл биднийг болон ер нь бизнесүүдийг хэн халамжилж, “авч явдаг” юм бэ? Гэрэлтэй, дулаантай албан тасалгаанд суух боломжийг хэн өгч байгаа юм бэ? Бидний цалинг хэн санхүүжүүлж байгаа юм бэ?

Харилцагчид! Хэрэв та манай харилцагч бол, та бас.

## Харилцагчид

### Бидний оршин тогтнох үндэс

Бизнес гэдэг ухагдахуун нь хүмүүст хэрэгцээтэй байгаа зүйлийг тэдэнд бий болгож өгөөд, түүнийхээ хариуд урамшуулал хүртэх явдал юм. Хүмүүст хэн илүү сайн зүйлсийг, илүү сайхнаар хүргэнэ, тэрээр бусдаасаа илүү амжилттай байна. Тэгэхээр ямар ч бизнес өөрийнхөө бүтээгдэхүүн үйлчилгээг хүлээн авч байгаа эцсийн хэрэглэгчийн төлөө буюу тэдэнд хамгийн сайхан мэдрэмж төрүүлэхийн төлөө оршин тогтнох ёстой гэж бид үздэг.

## Дэмжих Хамт Олон

### Халамжлагчдыг бүх төрлөөр дэмжих

Уулзсан бүхний сэтгэлийг хөдөлгөж, харилцагч болгонд гайхалтай сайхан сэтгэгдлийг үлдээхийн тулд Халамжлагч нарт маань хэрэгцээтэй байгаа бүхий л төрлийн дэмжлэгийг үзүүлж байх нь Дэмжих Хамт Олны оршин тогтнох зорилго нь юм. Үүнд бүтээгдэхүүн дизайны, үйл явцын (процессын), удирдлагын, эрсдэлийн, зах зээлийн харилцааны гэх мэтчилэн олон төрлийн дэмжлэгүүд багтана.

## Ариг Банкны удирдах ажилтнууд яагаад хамгийн доор/үүдэндээ суудаг вэ?

Олж уулзахад хамгийн хэцүү, арын, тусдаа өрөөнд нуугдан суух биш, харилцагч хаалгаар орж ирэхэд хамгийн ойрхон, ил байснаар өдөр тутмын асуудлуудтай ойр байж, ажилтнуудаа үлгэрээр удирдан, харилцагч болгонд гайхалтай сайхан сэтгэгдэл үлдээх зорилго маань нэг алхамаар ойртоно гэж Ариг Банкныхан үздэг юм. Та манай Харилцагчийн Өргөөд болон Дэмжих Байраар (Банкны Төв) зочлохдоо манай Манлай Халамжлагч болон Манлай Дэмжигчдийн ширээ, тасалгаагаар саатан, яриа өрнүүлээрэй.



## Харилцагчдыг Халамжлагчид

### Хамгийн чухал, нүүр царай

Харилцагчидтай өдөр тутам нүүр тулж, шууд харьцдаг энэ багтаа бид өндөр мэдрэмж, чин сэтгэл, харьцааны соёл, мэргэжлийн чадварын шаардлага тавьж байна. Энэ хамт олон маань бидэнд амин чухал бөгөөд харилцагчийн хэрэгцээ, сонголтын талаархи үнэтэй мэдээлэл, санал шүүмжийг бидэнд хүргэн, дутагдалтай байгаа үйлчилгээг Дэмжих Хамт Олноос нэн даруй шаардан сайжруулуулах эрх бөгөөд үүрэгтэй юм.

## Манлай Дэмжигч

### Халамжлагчдыг дэмжих үлгэр жишээ

Дэмжих Хамт Олны дотроос Манлай Дэмжигч (уламжлалт нэршлээр: Гүйцэтгэх Захирал) нь харилцагч болгонд гайхалтай сайхан сэтгэгдэл үлдээхийн тулд Халамжлагчдынхаа хамгийн хүчтэй дэмжигч нь байх ёстой бөгөөд Дэмжих Хамт Олныгоо үүнд уриалан дуудах үүрэгтэй юм.



# МОНГОЛ УЛСЫН 2017 ОНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ



**2017** онд Монгол улсын эдийн засгийн өсөлт 1.0 хувьд хүрч саарсан нь 2009 оноос хойшхи хамгийн доогуур үзүүлэлт болж байна.

**2010-2012** оны хооронд барилга болон худалдаа, санхүүгийн салбарын оруулж ирсэн хувь нэмэр эдийн засгийн өсөлтийн гол түлхүүр хүчин зүйл болж байсан бол 2013-2015 онд уул уурхайн салбарын өсөлт эдийн засгийн өсөлтөд голлох хувь нэмэр оруулж иржээ. 2017 оны тухайд уул уурхайн салбар үндсэндээ өсөлтгүй байсан бол уул уурхайн бус салбарууд 1.1 хувиар өслөө.

**2017** онд Монгол улсын ДНБ нэрлэсэн дүнгээр 23.9 их наяд төгрөг буюу 9.6 тэрбум ам доллараар хэмжигдэж байгаа бөгөөд 2010 оны зэрэгцүүлэх үнээр 16 их наяд төгрөгт хүрсэн байна. Энэ нь өнгөрсөн оноос 154.6 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлт бөгөөд тээвэр агуулах, хөдөө аж ахуйн салбар хамтдаа 246.8 тэрбум төгрөг буюу 8


хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Харин барилгын салбар 16 хувиар агшсанаар нийт үйлдвэрлэлийг 93.3 тэрбум төгрөгөөр бууруулах нөлөөг үзүүлжээ.


Худалдааны салбарт 2017 онд мөн уналт ажиглагдсан бөгөөд сүүлийн 2 жилийн хугацаанд нийт 11 хувиар агшсан дүнтэй байна.

**2017** он гарсаар бодлогын хүүнд 4 удаа өөрчлөлт оруулсан нь 2009 оноос хойш анхны тохиолдол байв. Тэр дундаа 8-р сард бодлогын хүүг 4.5 нэгж хувиар өсгөж 15 хувьд хүргэсэн нь Монгол Банкны зүгээс валютын захыг тогтворжуулахын тулд их хэмжээний интервенц хийхээс зайлсхийж, төгрөгийн уналтыг зогсоох бодлогын арга хэмжээ байлаа. Инфляцийн түвшин жилийн эцэст 1.1 хувьтай гарсан мах, хүнсний ногоо, орон сууц зэрэг ХҮИ-д жин дардаг бараа бүтээгдэхүүний үнэ харьцангуй тогтвортой буюу буурсан үзүүлэлттэй гарлаа.


Economical growth %



Inflation & Policy rate (%)



Exchange rate USD to MNT



# БАНКНЫ САЛБАРЫН 2017 ОНЫ ЕРӨНХИЙ ТОЙМ

2017 он банкны салбарын санхүүгийн үр дүнд эерэг өөрчлөлтүүд олон гарсны зэрэгцээ эрсдэлийн удирдлагын тогтолцооны хувьд томоохон сорилтуудыг даван туулж, туршлага хуримтлуулсан жил байлаа. Тухайлбал Монголбанкнаас олон улсын аудитийн байгууллагатай хамтран банкуудад активийн чанарын үнэлгээний шалтгалт хийж банкууд зээлийн бодлого, барьцаа хөрөнгийн үнэлгээний арга аргачлал нь олон улсын стандартад нийцэж буй байдалдаа дор бүрнээ үнэлгээ дүгнэлт өгөх боломжийг бүрдлээ. Зээлийн үнэ цэнийн бууралтыг тодорхойлж буй одоогийн стандартыг энэ оноор дуусгавар болгож, 2019 оноос эхлэн IFRS-9 стандартыг нэвтрүүлэх шаардлага тулгарч байгаа бөгөөд Монголбанк болон арилжааны банкууд, аудитийн компаниуд тус бүрдээ бэлтгэл ажлаа хангаж байна.

2017 оны хувьд системийн банкуудын өсөлт тогтвортой хадгалагдсаны зэрэгцээ Тээвэр Хөгжлийн банк болон Капитрон банкууд хөрөнгө, эх үүсвэрийн өсөлтийн хурдаараа салбартаа тэргүүлэх үр дүнг үзүүллээ.



Тайлант онд банкны салбарын нийт хөрөнгө 28.8 их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх оноос 13.6 хувиар өссөн үзүүлэлт юм. Нийт хөрөнгө 2013 оноос хойш жилд дунджаар 8.3 хувиар өссөн бол энэ хугацаанд өөрийн хөрөнгө жилд дунджаар 22.9 хувиар өссөн байна. Дотоодоос татсан эх үүсвэр буюу иргэд болон ААН-с татан төврөлүүлсэн харилцах хадгаламжийн үлдэгдэл 3.6 их наяд төгрөгөөр өссөн нь нийт хөрөнгийн өсөлтийг дангаараа бүрдүүлжээ. Ингэснээр харилцах хадгаламжийн үлдэгдэл зээлийн үлдэгдлээс давсан үзүүлэлттэй гарлаа. Зээлийн багцын өсөлт хэдийгээр эх үүсвэрийн өсөлттэй харьцуулахад бага байсан хэдий ч 9.5 хувиар өссөн бөгөөд өмнөх жил 6.1 хувиар өсч байснаас зээлийн өсөлт сэргэх хандлага ажиглагдсаны зэрэгцээ нийт эх үүсвэрийн хүрэлцээтэй байдлаас үзэхэд цаашид зээлийн багц үргэлжлэн өсөх боломжтой байна.

2013 оноос хойш зээлийн багц жилд дунджаар 6.0 хувиар, харилцах хадгаламжийн багц жилд дунджаар 14.2 хувиар өссөн байгаагаас үзэхэд сүүлийн 5 жилийн хугацаанд иргэдийн банканд итгэл, хуримтлах дадал зуршил нэмэгдэж байгаа эерэг хандлага ажиглагдаж байна.

Гадаад валютаар олгосон зээлийн багцын үлдэгдэл 2013 оноос хойш анх удаа өссөн үзүүлэлттэй гарсан бөгөөд гадаад валютаар олгосон зээл хадгаламжийн харьцаа 56 хувиас 67 хувь болж өссөн байна.

Чанаргүй зээлийн багцад эзлэх хувь 8.5 хувь буюу өмнөх оны түвшинд хадгалагдлаа. Чанаргүй зээлийн багцын үлдэгдэл 1,148 тэрбум төгрөг байгаа нь 2016 оноос 9.6 хувиар өссөн байна. Тус үзүүлэлт 2015 болон 2016 онуудад харгалзан 39.0 хувь болон 20.8 хувиар өссөнтэй харьцуулахад чанаргүй зээлийн багцын өсөлт саарч буй дүр зураг ажиглагдлаа. Чанаргүй зээлийн багц өсөхөд боловсруулах үйлдвэрлэл, үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа, хөдөө аж ахуйн салбарт олгосон зээлийн чанар муудсан нь голлон нөлөөлжээ. Харин бөөний жижиглэн худалдааны салбарт олгосон зээлийн багцын чанар огцом сайжирсан үзүүлэлттэй байна.


Банкны салбарын эрсдэл даах чадварын харьцаа буюу зээлийн эрсдэлийн сангийн хүрэлцээ сайжирч 88.3 хувьд хүрлээ. Өөрөөр хэлбэр системийн чанаргүй ангилал бүхий зээлийн 88 хувьд эрсдэлийн санг байгуулаад байна. 2017 онд арилжааны банкууд цэвэр дүнгээр 184 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн санг нэмж байгуулснаар системийн зээлийн эрсдэлийн сангийн хэмжээ анх удаа 1.0 их наяд төгрөгт хүрлээ.

2017 оны 10 дугаар сарын байдлаар өөрийн хөрөнгийн хүрэлцээ болон төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа харгалзан 17.4 хувь буюу 42.2 хувьтай байгаа нь зохистой харьцааны шалгуур үзүүлэлтээс тус тус 5.4 хувь болон 17.2 нэгж хувиар өндөр байна. Системийн хэмжээнд зээлийн багцын өсөлт өмнөх онуудтай харьцуулахад хурдассан үзүүлэлттэй байсан тул өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт өмнөх оноос бага зэрэг буюу 2.2 нэгж хувиар буурлаа.



2017 онд банкны салбар 249.1 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан өмнөх онтой харьцуулахад өсч, 2015 оны түвшинд хүрсэн үзүүлэлт байлаа. Хэдийгээр өөрийн хөрөнгийн өгөөж өсч 8.2 хувьд хүрсэн хэдий ч ЗГҮЦ-ны хүүнээс доогуур түвшинд хэвээр байна.

2017 онд зээл болон хадгаламжийн хүү харгалзан 0.7 болон 0.2 нэгж хувиар буурсан үзүүлэлттэй гарлаа. Хүүгийн зөрүү 6.1 хувь байгаа нь өнгөрсөн онтой харьцуулахад мөн 0.5 нэгж хувиар буурсан үзүүлэлт болж байна. Банкуудын харилцах хадгаламжийн зээлийн дүнгээс давсан, бодлогын хүү буурч 10.0 хувьд хүрсэн, өөрийн хөрөнгө болон зээлийн эрсдэлийн сангийн



хүрэлцээтэй байгаагаас үзэхэд 2018 онд зээл олголт эрчимжиж, зээлийн хүү үргэлжлэн буурах төлөвтэй байна.

Банкуудын АТМ-ны тоо 2000-г давж, ПОС машины тоо 27,304-т хүрч цахим сувгийн хүртээмж нэмэгдлээ. 2013 оноос хойш АТМ-ны тоо 2 дахин, ПОС машины тоо 3 дахин өссөн үзүүлэлттэй байгаа бөгөөд цахим сувгийн хүртээмжийн үзүүлэлтээр Монгол улс нь өндөр хөгжилтэй орнуудтай нэг түвшинд байна.





# Хараат бус АУДИТЫН ТАЙЛАН



Далай тауэр, ЮНЕСКО-гийн  
гудамж, Сүхбаатар дүүрэг-1,  
Улаанбаатар 14230,  
Монгол улс  
Т + 976 70 110744  
Ф + 976 70 110722

Dalai Tower, UNESCO street,  
Sukhbaatar District-1,  
Ulaanbaatar 14230, Mongolia  
T + 976 70 110744  
F + 976 70 110722

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

"Ариг Банк" ХХК-ийн хувьцаа эзэмшигчдэд:

### Дүгнэлт

Бид "Ариг Банк" ХХК (цаашид "Банк" гэх)-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан, уг өдрөөр дуусгавар болсон жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн гол бодлогын хураангуй, бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлан (цаашид "санхүүгийн тайлан" гэх)-д аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, "Ариг Банк" ХХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдал ба уг өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн үр дүн ба мөнгөн гүйлгээ нь бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн Монголбанкны Ерөнхийлөгч, Сайдын сайдын хамтарсан тушаалаар баталсан нягтлан бодох бүртгэлийн багц заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.

ГРАНТ ТӨРНТОН  
АУДИТ ХХК  
УЛААНБААТАР ХСТ  
Б.ОСОРГАВ  
УДИРДАХ ПАРТНЕР  
Монгол улс, Улаанбаатар хот  
2018 оны 3 дугаар сарын 29



Ариг Банк ХХК  
Санхүүгийн тайлан  
2017 оны 12 сарын 31

## САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН 2017 оны 12 сарын 31-нээр тасалбар болгосон.

(мянган төгрөгөөр)

	2017 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2016 оны 12 сарын 31-ний үлдэгдэл
<b>Балансын зүйл</b>		
<b>ХӨРӨНГӨ</b>		
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	64,313,594	34,897,369
Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө	7,673,319	7,227,575
Хөрөнгө оруулалт	4,997,653	1,370,753
Зээл (цэвэр дүнгээр)	45,782,705	52,265,006
Хэвийн зээл	43,429,875	47,556,381
Хугацаа хэтэрсэн зээл	894,430	1,079,659
Хэвийн бус зээл	614,478	2,861,770
Эргэлзээтэй зээл	538,053	1,541,487
Муу зээл	1,311,594	1,262,021
Зээлд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	984,886	859,538
Зээлийн эрсдэлийн сан	(1,990,611)	(2,895,850)
Бусад санхүүгийн хөрөнгө	315,360	475,526
Бусад санхүүгийн бус хөрөнгө	2,612,372	2,480,253
Үндсэн хөрөнгө	4,691,763	4,875,896
Борлуулах зориулалттай хөрөнгө	4,629,295	282,502
Биет бус хөрөнгө	457,483	318,725
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>135,473,544</b>	<b>104,193,605</b>
<b>ӨР ТӨЛБӨР</b>		
Харилцах	2,770,057	2,717,604
Хадгаламж	64,334,618	66,896,976
Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр	26,847,274	17,277,474
Бусад эх үүсвэр	990,947	209,933
Бусад санхүүгийн өр төлбөр	1,130,502	756,282
Бусад санхүүгийн бус өр төлбөр	700,835	155,728
<b>Нийт өр төлбөрийн дүн</b>	<b>96,774,233</b>	<b>88,013,997</b>
<b>ӨӨРИЙН ХӨРӨНГӨ</b>		
Хувь нийлүүлсэн хөрөнгө	35,009,500	16,290,000
Дахин үнэлгээний нэмэгдэл	189,723	129,578
Хуримтлагдсан ашиг, алдагдал	3,497,047	(243,011)
Бусад өөрийн хөрөнгө	3,041	3,041
<b>Өөрийн хөрөнгийн дүн</b>	<b>38,699,311</b>	<b>16,179,608</b>
<b>Өр төлбөр ба өөрийн хөрөнгийн дүн</b>	<b>135,473,544</b>	<b>104,193,605</b>

## ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН 2017 оны 12 сарын 31-нээр тасалбар болгосон.

(мянган төгрөгөөр)

Орлого, зардлын зүйл	2017 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон	2016 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон
<b>Хүүгийн орлого</b>	<b>16,838,658</b>	<b>17,036,355</b>
Монголбанкинд байршуулсан хөрөнгийн	367,186	22,140
Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө	140,526	72,973
Үнэт цаасны	5,076,405	1,617,694
Зээлийн	11,254,541	15,323,548
<b>Хүүгийн зардал</b>	<b>8,290,465</b>	<b>9,764,674</b>
Харилцахад төлсөн хүү	39,114	27,857
Хадгаламжинд төлсөн хүү	7,572,500	9,181,024
Зээлийн хүүгийн зардал	672,237	555,793
Бусад хүүгийн зардал	6,614	-
<b>Хүүгийн цэвэр орлого</b>	<b>8,548,193</b>	<b>7,271,681</b>
<b>Эрсдэлийн сангийн зардал</b>	<b>335,165</b>	<b>2,140,020</b>
<b>Эрсдэлийн сангийн дараах цэвэр орлого</b>	<b>8,213,028</b>	<b>5,131,661</b>
<b>Бусад орлого</b>	<b>26,932,304</b>	<b>66,528,936</b>
<i>Хүүгийн бус орлого</i>	<i>24,333,272</i>	<i>63,123,780</i>
Арилжааны орлого	444,410	301,039
Ханш, үнэлгээний тэгшитгэлийн орлого	23,303,598	61,816,481
Банкны бүтээгдэхүүнтэй холбоотой үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	526,439	466,372
Бусад хүүгийн бус орлого	58,825	539,888
<i>Бусад орлого, олз</i>	<i>2,599,032</i>	<i>3,405,156</i>
<b>Бусад зардал</b>	<b>30,733,124</b>	<b>68,872,026</b>
<i>Хүүгийн бус зардал</i>	<i>30,532,312</i>	<i>68,399,505</i>
Бусад эрсдэлийн сангийн зардал	165,871	773,487
Арилжааны зардал	295,655	220,945
Ханш, үнэлгээний тэгшитгэлийн зардал	23,222,035	61,463,142
Хураамж, шимтгэлийн зардал	189,269	33,666
Үйл ажиллагааны бусад зардал	6,659,482	5,908,265
<i>Бусад зардал, гарз</i>	<i>200,812</i>	<i>472,521</i>
<b>Татварын өмнөх ашиг, алдагдал</b>	<b>4,412,208</b>	<b>2,788,571</b>
Орлогын татварын зардал	672,150	357,202
<b>Татварын дараах ашиг, алдагдал</b>	<b>3,740,058</b>	<b>2,431,369</b>
Зогсоосон үйл ажиллагааны цэвэр орлого, зардал	-	-
<b>Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал</b>	<b>3,740,058</b>	<b>2,431,369</b>
Бусад дэлгэрэнгүй орлого	60,145	129,578
<b>Тайлант хугацааны нийт дэлгэрэнгүй орлогын дүн</b>	<b>3,800,203</b>	<b>2,560,947</b>




# ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ

Ариг Банкны хувь нийлүүлэгчдийн 60.46 хувийг Дэм санхүүгийн нэгдэл ХХК, 39.54 хувийг Улаанбаатар Импекс ХХК бүрдүүлж байна.

**ДЭМ САНХҮҮГИЙН НЭГДЭЛ** нь Ариг Банкны толгой компани бөгөөд 2014 оны 6 сарын 26-нд үүсгэн байгуулагдаж, гадаад худалдааны чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байна. Европ болон Азийн орнуудаас импортоор бүх төрлийн бараа бүтээгдэхүүн нийлүүлэхээс гадна дотоодын үйлдвэрлэгчдийг дэмжиж тэдний бараа бүтээгдэхүүнийг гадагшаа экспортлох, мөн зуучлалыг хариуцан, бизнесээ амжилттай өргөжүүлсээр байна.

**УЛААНБААТАР ИМПЕКС ХХК** нь үндэсний шилдэг компаниудын нэг Номин Холдинг ХХК-ийн охин компани бөгөөд импортлогчид, үйлдвэрлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг эрүүл ахуй, стандарт шаардлагын дагуу хадгалж, хэрэглэгчдэд найдвартай хүргэхээр ачаа тээвэр механизм, тээвэр зууч бүрдүүлэлтийн зууч, гаалийн баталгаат агуулахын үйлчилгээнүүдийг нэг дороос хүргэн ажиллаж байна.

# БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



# ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

ТУЗ нь үйл ажиллагаагаа явуулах зорилгоор тодорхой асуудал хариуцсан хороодыг байгуулж ажилладаг. Өнгөрсөн хугацаанд Ариг Банкны ТУЗ нь Аудитын хороо, Эрсдэлийн хороо, Хүний нөөц, цалин урамшууллын хороотойгоор ажилласан.



БҮРЭНЖАРГАЛЫН ЭРДЭНЭ-САНАА  
ТУЗ-ийн дарга, Хараат бус гишүүн

Б. Эрдэнэсанаа нь “Сигнум Ресурс” компанийн захирлаар болон 2010 оноос одоог хүртэл Ариг Банкны ТУЗ-ийн Хараат бус гишүүнээр тус тус ажиллаж байна. Тэрээр Худалдаа Хөгжлийн Банканд 1991 оноос хойш ажиллан Американ Экспресс, Виза, Мастер, JCB зэрэг олон улсын төлбөрийн картын үйлчилгээг Монгол улсад анх удаа нэвтрүүлсэн, ИнвэссКом санхүүгийн компанийг үүсгэн байгуулж MoneyGram олон улсын мөнгөн гуйвуулгын үйлчилгээний сүлжээг улс даяар нэвтрүүлсэн Монголын Банкны салбарын арвин туршлага бүхий шилдэг мэргэжилтэн бөгөөд Монголд бизнесийн зөвлөх анхдагч фирмийг үүсгэн байгуулж, удирдаж байсан юм.



ПҮРЭВИЙН  
МӨНХ-ЭРДЭНЭ  
Хараат бус гишүүн

Ноён уул Эрдэнэ ХХК-ийн гүйцэтгэх захирал



САНЖААГИЙН САЙНБАТ  
ТУЗ-ийн гишүүн

Номин Холдинг ХХК-ийн гүйцэтгэх захирал



ДАВААХҮҮГИЙН СЭРГЭЛЭН  
ТУЗ-ийн гишүүн

Эрэл ХХК-ийн Ерөнхий захирал



ДАВААХҮҮГИЙН ТӨМӨРХҮҮ  
ТУЗ-ийн гишүүн

Ариг Банкны Манлай дэмжигч



БАЛДАНДОРЖИЙН АРИУНЖАРГАЛ  
ТУЗ-ийн гишүүн

Номин Холдинг ХХК-д Санхүү бизнес эрхэлсэн захирал



ЭРДЭНЭБАТЫН ЖАРГАЛАН  
ТУЗ-ийн гишүүн

“Эрэл Холдинг” ХХК-ийн Гүйцэтгэх захирал





АРИГ БАНК

Цэвэр, Тунгалаг

Ариг гэдэг үгний "Цэвэр, Тунгалаг" гэсэн утгыг график дизайны "technique" буюу "тунгалаг арга"-ыг ашиглан логондоо тусгалаа. онцлог тал нь бол хэрэглэгдэж байгаа бүхий л...

# МАНЛАЙ ДЭМЖИГЧДИЙН НЭГДЭЛ

## ДАВААХҮҮГИЙН ТӨМӨРХҮҮ Ариг Банкны Манлай дэмжигч

Д.Төмөрхүү нь Бостоны "Уэйнврайт" банканд харилцагчийн менежер, Бостоны "Смит Барни"-д зөвлөх, Нью Йорк хотын "Ди Жэй Пропертис"-т түншийн удирдлагын менежерээр ажиллаж байсан юм.

Тэрээр АНУ-ын Нью Йорк хотын Пэйс Их сургуулийн Санхүүгийн удирдлагын магистр, Отгонтэнгэр Их сургуулийн Хавсарга хэл шинжлэлийн бакалаврын зэрэг тус тус хамгаалсан.



Балданжамцын **АМАРЖАРГАЛ**  
Манлай дэмжигч  
Бизнес дэвжээх нэгдэл

Б. Амаржаргал нь 2014 оноос Ариг Банканд ажиллаж


байна. Тэрээр Хасбанканд салбарын захирал, бүсийн захирал зэрэг албан тушаалыг 7 жилийн турш хашиж банкны үйл ажиллагааны удирдлагын чиглэлээр туршлага хуримтлуулсан. 2008-2012 онд Энержи Ресурс ХХК-д Логистик хангамж, Эрсдлийн удирдлага дотоод хяналтын газрын даргын албан тушаалд тус тус ажиллаж байсан. Монгол Улсын Техникийн Их сургуулийг 2003 онд дүүргэж Бизнесийн удирдлагын бакалаврын зэргийг Санхүүгийн менежментээр авсан билээ.



Раднаагийн **НАРАНБААТАР**  
Манлай дэмжигч  
Жолоодлогоор дэмжих жигүүр

Р. Наранбаатар нь 2002 оноос Ариг Банканд

ажиллаж байгаа бөгөөд ажиллах хугацаандаа дотоод хянан шалгагч, Борлуулалт эрхэлсэн захирал зэрэг ажлыг гүйцэтгэж байгаад 2015 оноос Жолоодлогоор дэмжих жигүүрийн манлай дэмжигчээр ажиллаж байна. Тэрээр 1996 оноос ХОТШ банкны дотоод хянан шалгагч, 1999 оноос 2002 он хүртэл USAID, Говийн бизнесийн хөгжил төслийн малчны зээл хариуцсан төслийн ажилтан зэрэг албан тушаалд тус тус ажиллаж байсан. Нийт 21 жилийн банкны болон удирдах ажилтны туршлага хуримтлуулсан. СЭЗДС-ийг банкны эдийн засагч мэргэжлээр төгссөн



Нанзадбаярын **ОРХОН**  
Манлай дэмжигч  
Хамт олныг халамжлах жигүүр

Н.Орхон нь банкны салбарт 14 дэхь жилдээ ажиллаж


байгаа бөгөөд Капитал банканд Ерөнхий зохицуулалт, Иргэдийн банк, Бүртгэл тооцооны газарт мэргэжилтэн, Ахлах мэргэжилтнээр мөн ТУЗ-ийн Нарийн бичгийн даргаар тус тус ажиллаж байгаад 2010 оноос Ариг Банканд Хүний нөөцийн менежер, Хамт олныг халамжлах жигүүрийн Тэргүүн дэмжигч, Манлай дэмжигчээр ажиллаж байна. Банкны Нягтлан бодогч-Эдийн засагч мэргэжлээр бакалавр, Бизнесийн удирдлагын магистр зэрэгтэй.



Батхүүгийн **МӨНХБАЯР**  
Манлай дэмжигч  
Технологиор Дэвжүүлэх Жигүүр

Б.Мөнхбаяр нь СЭЗДС-д Бизнесийн у д и р д л а г ы н


чиглэлээр бакалавр, ШУТИС-д Компьютерийн чиглэлээр магистр хамгаалсан. Сүүлийн 18 жилийн туршид холбоо, мэдээлэл технологи, програм хангамж, банк санхүү болон худалдаа, импорт, ханган нийлүүлэлт, хадгалалт, эрүүл мэнд, эм зүй, засгийн газар болон төрийн бус байгууллагуудад голчлон удирдах түвшний алба хашсан байна. 2014 оноос Ариг Банканд ажиллаж байна.



Батсайханы **ОЮУНЦЭЦЭГ**  
Манлай дэмжигч  
Зочломтгой ёсны жигүүр

Б.Оюунцэцэг нь 16 жил банкны салбарт тасралтгүй

ажиллаж байгаа бөгөөд Зоос банкнаас ажлын гараагаа эхэлж тус банканд Маркетингийн менежер, ахлах менежер, Хадгаламж банканд Харилцагчийн үйлчилгээний хэлтсийн захирал, ҮХО-ын банканд Иргэдийн банкны газрын захирал зэрэг албан тушаалуудыг хашиж байсан. Сэрүүлэг дээд сургуулийг Бизнесийн удирдлагын менежер, СЭЗДС-ийг санхүүгийн менежер мэргэжлээр бакалавр, Удирдлагын академийг Бизнесийн удирдлагын магистр зэрэгтэй тус тус суралцаж төгссөн.



Цэндийн **ДАМДИНСҮРЭН**  
Манлай дэмжигч  
Дотоод хяналтын жигүүр

МУИС-ийн Эдийн засгийн факультетийг Зээлийн эдийн

засагч мэргэжлээр төгссөн. 1985 оноос зээл, дотоод хяналт, аудитын чиглэлээр банкны системд 33 дах жилдээ ажиллаж байна.



## КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

Зохистой засаглал нь банкны бизнесийг тогтвортой байдлаар амжилттай хөгжүүлэх үндэс суурь болдог. ТУЗ болон гүйцэтгэх удирдлага нь хувьцаа эзэмшигчид болон харилцагчид, ажиллагсад болон бусад олон нийтийн нэгдмэл сонирхолтой талуудын эрх ашгийг хамгаалах үүднээс засаглалын зохистой хэм хэмжээг баримталж хэрэгжүүлдэг. Ариг Банкны засаглалын тогтолцоо нь гадаад болон дотоод, том болон жижиг зэрэг бүх хувьцаа эзэмшигчид тэгш эрхтэй байх, бүх шатандаа тайлагнах, мэдээлэл өгөх, ил тод байдлыг хангах, нэгдмэл сонирхолтой бүх талуудын өмнө хариуцлага хүлээх зэрэг зарчмууд дээр үндэслэдэг.



## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

Банкны эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал юм. Банкны дотоод журмын дагуу Дэм Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн хувьцаа эзэмшигч Б.Эрдэнэбат, Улаанбаатар Импэкс ХХК-ийн хувьцаа эзэмшигч Ш.Баярсайхан нар Банкны хувьцаа эзэмшигчээр ажилладаг. Тайлант жилд хувьцаа эзэмшигчид хуралдаж, Банкны ирээдүйн өсөлтийг хангах, Монголбанкны зөвлөмжийг биелүүлэх үүднээс ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн.

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Ариг Банкны ТУЗ нь байгууллагын бүхий л шатанд ил тод, үнэнч шударга байдлыг чухалчлан, нээлттэй засаглалыг бий болгохын зэрэгцээ ямар ч нөхцөлд тохирсон алсын хараа, стратеги бүхий бодлогоор банкны үйл ажиллагааг чиглүүлж, дэмжин ажилладаг. Монгол улсын хууль тогтоомжоос гадна системийн банкны хувьд Ариг Банк нь банкны салбарын зохицуулагч Монголбанк (Төв Банк)-аас гаргадаг засаглалын дүрэм, журмын заалтуудыг дагаж мөрдөх үүрэгтэй. 2014 оны 9-р сард Монголбанкнаас шинэчлэн батлагдсан “Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам”-ын дагуу зохистой засаглалын тайлан гаргадаг. 2015 оны 2-р сард Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Сангийн сайдын шинэчлэн батласан “Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийг нэр дэвшүүлэх, сонгох, чөлөөлөх журам”-ын дагуу хоёр шинэ хараат бус гишүүнийг ТУЗ-д сонгосон. Тайлант жилд ТУЗ-ийн 11 удаагийн хурал хийснээс ТУЗ-ийн 7 гишүүний 100 хувь ирцтэйгээр 7 удаа, ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны 3 гишүүний 100 хувь ирцтэйгээр 3 удаа, Эрсдэлийн хорооны 3 гишүүний 100 хувь ирцтэйгээр 1 нэг удаа тус тус хуралдсан болно.





### Карьер хөгжлийг дэмжих чиглэлээр

Ажилтнуудын карьер хөгжлийг дэмжих үүднээс банканд нээлттэй байгаа ажлын байрны 100%-ийг дотоод эх үүсвэрээс сонгон шалгаруулсан ба дэвшин томилогдсон 22 ажилтан байна. 8 ажилтан тутмын нэг нь карьераа өсгөсөн үзүүлэлттэй байна. Мөн банкны ажилтнуудыг тогтвортой, үр бүтээлтэй ажиллуулах бодлогыг хэрэгжүүлсний үр дүнд ажилтнуудын ажилласан жилийн дундаж хугацаа 3 жил.

### Сургалт хөгжлийн чиглэлээр



Харилцагчийн үйлчилгээний мэргэжилтэнд тусгайлан зориулсан сургалтын шинэ хөтөлбөр боловсруулж, нийт харилцагчийн үйлчилгээний мэргэжилтнүүдийг харилцагчийн үйлчилгээний ур чадварын болон зээлийн суурь сургалтад хамруулав.

Түүнчлэн хувийн банкируудын биеэ авч авах хувийн соёлыг дээшлүүлэхээс эхлүүлэн бүтээгдэхүүн, даатгалын зуучлалын мэдлэгийг нэмэгдүүлэх, борлуулалт, харилцааны ур чадварыг бий болгоход онцгой ач холбогдол өгч, зааж чиглүүлэн, өргөн хүрээнд сургалаа.

### Эрүүл мэнд, Чөлөөт цаг чиглэлээр

Нийт ажилтнуудын эрүүл мэнддээ анхаарах болон чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор сар бүр хамт олон чиглэсэн арга хэмжээ зохион байгуулахаас гадна тогтмол 7 хоног бүрийн мягмар гарагт ширээний теннис, пүрэв гарагт гар бөмбөг, сагсан бөмбөгөөр хичээллэх боломжийг байгууллагын зүгээс бүрдүүлэн өгч ажиллаж байна.

### Цалин урамшуулал, нийгмийн халамжийн чиглэлээр

Цалин урамшууллын системийг сайжруулж, ажлын гүйцэтгэлтэй холбох үр дүнтэй ажлыг нэвтрүүлж, ажилтнуудын идэвхийг өрнүүлэх чухал хэрэгслийн нэг болох материаллаг бус урамшууллын хэлбэрийг өргөн ашигласнаар нийт ажилтнуудын 10% нь төрийн болон бусад байгууллагын шагналаар шагнагдсан байна.

## ХАМТ ОЛНЫГ ХАЛАМЖЛАХ ЖИГҮҮР

Ажилтнууд маань бидний амжилтын үндэс билээ. Ариг Банкны Хүний нөөцийн бодлого нь ажилтнуудаа өрсөлдөхүйц цалин хөлсөөр ханган, тэдэнд сургалт хөгжлийн болон хөдөлмөр эрхлэлтийн эрх тэгш боломж олгож, эрүүл, аюулгүй ажлын байрыг бүрдүүлэх, мөн ажлын байрны олон талт бүтцийг дэмжихэд оршино.

Ариг Банк нь 2017 онд нийт 85 ажилтныг сонгон шалгаруулж шинээр ажлын байраар хангасан бөгөөд ажилтнуудаа тогтвортой үр бүтээлтэй ажиллах, тасралтгүй хөгжих боломжоор хангах зорилго тавьсны дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.





# МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН


## ИМЭЙЛ БАТАЛГААЖУУЛАЛТ

Технологийн дэвшилтэт системийг ашиглан харилцагчийн үнэт цагийг хэмнэх зорилгоор гаргаж ирсэн хэд хэдэн үйлчилгээний нэг нь имэйл баталгаажуулалт юм. Харилцагч өргөөн дээр ирэлгүйгээр орон зайнаас үл хамааран өөрийн Зөвлөн халамжлагчиддаа гүйлгээний захиалгыг өгсөнөөр хариуцсан Зөвлөн халамжлагч гүйлгээг системд шивж, програмаас автоматаар бүртгэлтэй имэйл хаяг руу зөвшөөрөл хүссэн баталгаажилтын цахим шуудан явуулахыг хэлнэ. Програмаас гүйлгээ гарахад ажилтан оролцохгүй бие даан гардагаараа том давуу талтай буюу найдвартай юм.



## ИНТЕРНЭТ БАНКААР ЗЭЭЛЭЭ ТӨЛБЕ

Харилцагчийн цаг завьг хэмнэх зорилготой гарсан бас нэгэн үйлчилгээ нь интернэт банкны зээлийн төлөлт цэс юм. Харилцагчид заримдаа зөвхөн зээлийн төлөлт хийхээр Харилцагчийн өргөөдийг зорьж очдог бол харин одоо харилцагч хүссэн үедээ өөрийн интернэт банкиг ашиглан зээлийн хүүг урьдчилан төлөх, зээл хаах, зээлээс төлөлт хийх зэрэг үйлдлүүдийг банкин дээр очих шаардлагагүйгээр цагаа хэмнэхэс гадна гэрээсээ, ажлаасаа хүссэн газраасаа хийх боломжтой болсон.



## ДУУДЛАГЫН БАНКНЫ ҮЙЛЧИЛГЭЭ

Харилцагчид заримдаа банк орох завгүй үед яаралтай мөнгөний хэрэгцээ гарах нь цөөнгүй. Ийм үед харилцагчийн хүссэн газарт мөнгийг хүргэж өгөх, мөнгө хүлээж авах зэрэг үйлчилгээг үзүүлсэнээр харилцагчид маань банкны үйлчилгээг хүссэн газраасаа авч, цагаа хэмнэх боломжийг бүрдүүлсэн үйлчилгээ болж чадсан. Харилцагч дуудлагын банкны үйлчилгээг авахдаа зөвхөн өөрийн байгаа газар мөнгийг хүргүүлээд зогсохгүй, гуравдагч этгээдэд өөрийн нэрийн өмнөөс мөнгө хүргүүлэх/авах боломжтой юм.





# ПОКЕТБАНКАА ШИНЭЧИЛЖ ИЛҮҮ ХЯЛБАР БОЛГОЛОО

Смарт утас бидний амьдралын салшгүй хэсэг болж байна. Тиймээс бид банкны бүтээгдэхүүн, үйлчилгээг ч мөн смарт утсанд багтааж, ашиглахад хялбар, аюулгүй банкны бүтээгдэхүүн үйлчилгээнүүдийг харилцагчиддаа санал болгохоор хичээнгүйлэн ажиллаж байна.

Бид Покетбанкаа шинэчилж, харилцагч өөрийн Покетбанк руугаа нэвтрэх бүртээ нууц үгээ бичиж оруулах шаардлагагүй бөгөөд хурууны хээгээ уншуулах эсвэл паттерн зохиож орлуулах боломжтой боллоо. Мөн харилцагч өөрийн дуртай өнгөөрөө загвараа сольж, өөрт таатай орчныг бүрдүүлэн ажиллах боломжтой



2017 онд банкны системийн найдвартай ажиллагаа 99.80% байхаар зорилт тавин ажилласан бөгөөд бодит гүйцэтгэлээр 99.88%-ийн найдвартай ажиллагааг хангаж төлөвлөсөн зорилтоо биелүүлсэн.

Банкны мэдээллийн технологийн дэд бүтэцийн түвшинд аюулгүй байдлыг сайжруулах ажлын хүрээнд Next Generation Firewall суурилуулж нэвтрүүлсэн. Бизнесийн үйл ажиллагааг

автоматжуулах, харилцагчийн үйлчилгээг сайжруулах зорилгоор банкны үндсэн системд Кредит карт, Авизийн автомат буцаалтийн модулийг нэвтрүүлсэн, Монгол банкны зээлийн мэдээллийн системтэй харьцдаг программийг шинээр хөгжүүлсэн, өргөөдийн ханшийн дэлгэцийн ажиллагааг найдвартай, өнгө үзэмжтэй болгож илүү ухаалаг, эмбэдэд төрлийн шийдэл нэвтрүүлсэн зэрэг амжилттайгаар 2017 оныг үдэж байна.

## МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИ



# НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

## “МӨНГӨ ТАНЫГ УДИРДАХ УУ, ТА МӨНГИЙГ УДИРДАХ УУ” САНХҮҮГИЙН СУРГАЛТ

Бид 2017 онд Монгол банк, Сангийн яам, Боловсрол, Соёл шинжлэх ухааны яам болон Санхүүгийн зохицуулах хорооноос хэрэгжүүлж буй олон нийтийн санхүүгийн суурь боловсролыг нэмэгдүүлэх хөтөлбөрт нэгдэж, бямба гараг бүр өөрийн байранд санхүүгийн сургалтуудыг тогтмол зохион байгуулж, олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэхээр хичээнгүйлэн ажиллаа.



## 2017 ОНЫ ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТИЙН МАНЛАЙЛАГЧ БАЙГУУЛЛАГА

2017 оны туршид бид нийт 2,000 гаруй иргэдийн санхүүгийн суурь мэдлэгээ нэмэгдүүлэхэд нь хөрөнгө оруулалт хийж, бодит хувь нэмрээ оруулаад байна. Тогтвортой санхүүжилтийн хүрээнд хийж буй ажлуудаараа Монголын байгууллагуудыг манлайлах эрхэм үүргийг хүлээгээд байна.







## АРИГ БАНКНЫ ХАМТ ОЛНЫ НИЙГМЭЭ ГЭСЭН СЭТГЭЛЭЭР 2017 ОНЫ ТУРШИД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛУУД

Ариг Банк нь 2013 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр “Монгол Улсын нийгэм, байгаль орчинд ээлтэй Тогтвортой санхүүжилтийн бодлогыг хөгжүүлэхийн төлөөх хамтарсан тунхаг бичиг”-т гарын үсэг зурж Монголын Тогтвортой санхүүжилтийн хөтөлбөрт нэгдсэн. Ариг банк нь ТоС нэгдсэн цагаасаа эхлэн банкны холбогдох үйл ажиллагаа, стратеги, бодлого-д ТоС-ийн зарчмуудыг нягт шигтгэн суулгасан. Ариг Банкны байгаль орчин, нийгмийн хариуцлагын хүрээнд зохион байгуулагдаж буй бүх ажлууд нь Монголын Тогтвортой Санхүүжилтийн хөтөлбөрийн 8 зарчмын дагуу хийгддэг болно.

2017 оны турш Ариг банк Тогтвортой санхүүжилт, нийгмийн хариуцлагын маш олон төсөл хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлсэн байна.

## УЛААН ЧУЛУУТЫН ХОГИЙН ЦЭГИЙН ЗАЛУУСЫГ ДЭМЖИН АЖИЛЛАЖ БАЙНА

2017 онд Ариг Банкны Өрх засах багийн хамт олон Улаан чулуутын хогны цэг дээр хог түүж амьдралаа залгуулдаг хоёр залууст хаягдал хуванцар савыг ашиглан хэрхэн буйдан хийх талаар сургалт орж, аргыг зааж өгсөн талаар мэдээлж байсан билээ. Тэгвэл аяганы хариу өдөртөө гэгчээр сайхан сэтгэлээр эхэлсэн тэрхүү ажил маань төсөл болон хэрэгжихээр болсоныг дуулахад маш сайхан байна.



Улаан чулуутын хогны цэг дээр амьдардаг өрхүүдийн хүүхдүүдэд цэцэрлэгийн боловсрол олгох, хүмүүжүүлэх зорилготой ажилладаг “Нарны хүүхдүүд” цэцэрлэг нь Канад Улсын Гадаад харилцааны яамнаас санхүүжүүлэн хэрэгжүүлдэг “Канад сангийн орон нутгийн санаачилга” хөтөлбөрийн 2017-2017 оны шалгаруулалтанд тэнцэж, санхүүжилт авахаар болсон юм. Уг төслийн зорилго нь тус цэцэрлэгийн дэргэд оёдлын жижиг цех

байгуулж, Улаанчулуут дах хогийн цэг дээр амьдардаг иргэдэд тогтвортой ажлын байр бий болгох явдал юм. Ийнхүү хуванцар саваар хэрхэн буйдан хийхийг сурсан залуус маань буйдангаа хийж борлуулан, тогтмол орлого олох боломжтой боллоо.

Нэг ч гэсэн өрх хог түүхгүйгээр амьжиргаага залгуулах орлоготой болж байгаа нь юутай сайхан хэрэг вэ! Та бид ч гэсэн дөнгөж үйлдвэрлэлээ эхэлж буй хүмүүсийг дэмжиж буйдан болон бусад төрлийн бүтээгдэхүүнүүдээс нь худалдан авч дэмжих боломжтой.





# “МӨНГӨ ТАНЫГ БИШ, ТА МӨНГИЙГ УДИРДАХ УУ?” Харилцагчийн санхүүгийн сургалт

Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийн дээшлүүлэх хөтөлбөрийн хүрээнд дэмжих “Мөнгө таныг биш, Та мөнгийг удирдах уу” харилцагчийн санхүүгийн сургалт. 2017 оны турш долоо хоног бүрийн бямба гараг болгон сургалтыг хүний хөгжлийн АФА Академи хамтран Ариг Банкны дэмжих байранд зохион байгуулж байна. Сургалтад 2017 оны 12-р сарын эхний байдлаар 1,500 иргэд, харилцагчид хамрагдан, санхүүгийн анхан шатны мэдлэгтэй болсон. Сургалтын хөтөлбөрийн дагуу харилцагчид

- Өдөр тутмын үргүй зардлыг бууруулах, энгийн хэмнэлтийн аргуудад суралцах
- Амьдралын төвшин, чанараа бууруулахгүйгээр хуримтлалтай болох
- Мөнгийг өөрийнхөө төлөө хэрхэн ажиллуулах талаар судлах
- Хөрөнгөтэй болох энгийн аргуудад суралцаж, санхүүгийн төлөвлөгөөтэй амьдрах

талаар, мэдлэг өгдөг. Сургалтын 30 минутын завсарлагаар Ариг Банкны Дэмжих байртай танилцаж байгальд ээлтэй, эрчим хүчний хэмнэлттэй, Нарны цахилгаан үүсгүүрийг хэрхэн офис-т ашиглах талаар танилцуулах аялал хийж, туршлага хуваалцдаг. Ариг турыг явцад Монголын Тогтвортой санхүүжилтийн

хөтөлбөр, түүний зорилго, санаачлагуудын талаар мэдээлэл туршлагауудыг танилцуулсан.



Дэм Дэмэндээ

ДЭМ ДЭМЭНДЭЭ нь хүмүүнлэгийн дэлгүүр бөгөөд иргэд өөрт илүүдэл болон хандивлахыг хүсч байгаа хувцас, эд хогшлыг хандивлан зориулалтын дэлгүүрээр дамжуулан хэрэгцээтэй хүмүүст нь түгээх олон улсын туршлага юм. Улаан Загалмай Нийгэмлэг энэхүү хандивын туршлагыг дэлхийн олон улсад амжилттай хэрэгжүүлдэг бөгөөд Монголд анх удаа Ариг Банк санаачлан, өөрийн харилцагчийн өргөөдөд байрлуулсан зориулалтын хайрцагт иргэдийн хандивын эд зүйлс, хувцсыг цуглуулан ДЭМ ДЭМЭНДЭЭ хүмүүнлэгийн дэлгүүрээр дамжуулан хэрэгцээт хүмүүст нь хүргэх ажлыг эхлүүлэн ажиллаж байна.

ДЭМ ДЭМЭНДЭЭ-ийн зорилго юу вэ?

Иргэд, та бидэнд байдаг хэрэглэхээ больсон эд зүйлсийг хэрэгцээтэй байгаа хүмүүст нь өгөх, бусдад туслах сэтгэл байдаг боловч тэр болгон

# УЛААН ЗАГАЛМАЙН НИЙГЭМЛЭГТЭЙ ХАМТАРСАН “ДЭМ ДЭМЭНДЭЭ ХҮМҮҮНЛЭГИЙН ДЭЛГҮҮР ТӨСӨЛ”

хэнд хандах, хаана аваачиж өгвөл хэрэгтэй хүндээ очих талаар мэдээлэл муу байдаг. Тэгвэл ДЭМ ДЭМЭНДЭЭ хүмүүнлэгийн дэлгүүр маань бусдад туслах, хандивын эд зүйлсийг хүлээн авах тэрхүү газар яг мөн бөгөөд та, бид тус газраар дэмжуулан амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой, нэн ядуу, эмзэг бүлгийн иргэд, оюутан, ажилгүй залуучууд, өрх толгойлсон эцэг, эх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажлын байраар хангах, сургалтад хамруулах, тэднийг нийгэмшүүлэхэд туслах боломжтой юм.

Таны хандивласан бараа бүтээгдэхүүн, эд зүйлс, хуучин хувцсыг бид хүлээн авч, зорилтот бүлгийн иргэд болох амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой иргэдэд ДЭМ ДЭМЭНДЭЭ хүмүүнлэгийн дэлгүүрээр дамжуулан хүргэдэг юм.



# ХҮҮХДИЙН ТӨВ СУВИЛЛЫН УСАН ЭМЧИЛГЭЭНИЙ ӨРӨӨНИЙ ЗАСВАР



бэрхшээлтэй байнгын мэргэжлийн онцгой асаргаа, халамж шаардлагатай бяцхан үрс эмчлүүлдэг бөгөөд тэдэнд 100% физик, тэр дундаа усан эмчилгээ хийлгэх зайлшгүй шаардлагатай байдаг. Усан эмчилгээний тасаг нь агааржуулалтын хоолой байхгүйн улмаас хана, таазны будаг, замаска хууларч унасан, хүүхдүүдэд усан эмчилгээг бүрэн хийх боломжгүй байсаныг Ариг банк дугтуй зарж цуглуулсан мөнгөөрөө агааржуулалтын хоолойг шинээр хийн засварласан бөгөөд ханын будаг, зураг чимэглэлийн ажлыг Ариг банкны залуус өөрсдөө чөлөөт цагаараа хийсэн.

Ариг Банк нь жил бүрийн цагаан сараар мөнгөний дугтуй хийн борлуулдаг бөгөөд дугтуйны орлогыг 100% сайн үйлсийн аянд зориулдаг. 2017 оны цагаан сараар борлуулсан дугтуйны орлогыг хуучнаар 3 ихэрийн сувилал буюу Хүүхдийн төв сувиллын усан эмчилгээний тасгийн бүрэн засварлаж өглөө. Хүүхдийн төв сувилал нь 1986 онд ашиглалтад орсон бөгөөд төсөв санхүү хүрэлцээгүйн улмаас капитал засвар огт хийж байгаагүй юм. Хүүхдийн төв сувилалд бүтэн өнчин, улсын халамжинд байдаг, хөгжлийн



## МАРАФОН ИТГЭЛ НАЙДВАР БОЛОМЖ УЛААНБААТАР 2017

Ариг банк, Ахиллис Монгол ТББ жил бүр зохион байгуулдаг "Итгэл найдвар, Боломж-Улаанбаатар" 2017 бүх нийтийн хандивын марафон гүйлт 2017 оны 9-р сарын 10-нд Үндэсний Цэцэрлэгт хүрээлэнд боллоо. Жил бүр гүйлтэд оролцогч, дэмжигч иргэд, байгууллага, хандивлагчдын тоо нэмэгдсээр байгаа энэ удаагийн гүйлтэд 3800 оролцогч албан ёсоор хандив өргөн гүйж, 10000 гаруй иргэд дэмжин оролцсон.

Марафоны үеэр цугларсан хандивыг 100% хөгжлийн бэрхшээлтэй тамирчдын тив дэлхийн уралдаан тэмцээнд оролцох зардалд зориулж байна.





## “АРИГ ТУР” НОГООН ОФИСТОЙ ТАНИЛЦАХ АЯЛАЛ

Ариг Банкны төв байр буюу Дэмжих байр нь Цахилгааны болон усны хэрэглээ бага, сэргээгдэх эрчим хүчээр цахилгааны хэрэглээний 65% хангадаг НОГООН ОФФИС юм. 2017 оны турш улсын болон хувийн хэвшлийн маш олон байгууллага, төсөл хөтөлбөрүүд Дэмжих байранд зочлон Ариг турд хамрагдан байгаль ээлтэйгээр оффисийн төлөвлөлтийг хийж болох санаа шийдлүүдтэй танилцсан.

Үүнд:

- Эрчим хүчний зохицуулах хороо
- Зориг сан, Байгаль орчны манлайлагч хөтөлбөр
- БОАЖЯ, Цэнгэг усны газар
- JICA Олон улсын байгууллага
- АНУ Элчин сайдын яам
- Их Британийн Элчин сайдын яам
- Schulze Global Investment
- UNICEF
- IFC
- Нийслэлийн байгаль орчны газар

Тогтвортой хөгжлийн боловсрол төсөл зэрэг байгууллагууд Ариг Банкны Дэмжих байртай танилцаж байгальд ээлтэй, эрчим

хүчний хэмнэлттэй, Нарны цахилгаан үүсгүүрийг хэрхэн офис-т ашиглах талаар танилцуулах аялал хийж, туршлага хуваалцсан. Ариг турын явцад Монголын Тогтвортой санхүүжилтийн хөтөлбөр, түүний зорилго, санаачлагуудын талаар мэдээлэл туршлагауудыг танилцуулдаг.

**НҮБ**-ийн хүүхдийн сантай хамтран байгууллагын нийгмийн хариуцлага: “хүүхдийн эрх, байгууллагын нийгмийн хариуцлагын зарчим” сэдэвт сургалт

2017 оны 11 сарын 15, 16-ны өдрүүдэд Ариг Банкны ажилтнууд Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хүүхдийн сангаас зохион байгуулсан “Хүүхдийн эрх - Байгууллагын зарчим” сэдэвт сургалтанд амжилттай хамрагдлаа.

Тус сургалтаар Хүүхдийн эрхийн асуудал яагаад бизнесийн байгууллагуудтай холбогддог, байгууллагууд яагаад дотоод үйл ажиллагаандаа Хүүхдийн эрхийг дээдэлсэн дүрэм журам баримтлан ажиллах хэрэгтэй талаар голчлон авч хэлэлцсэн. Мөн Монгол улсын хэмжээнд хүүхдийн хөдөлмөр эрхлэгч хүүхэд нийт хүүхдүүдийн хэдэн хувийг эзэлж байгаа талаар тоо баримттай мэдээлэл өгсөн юм.

Сургалтын үеэр сургалтанд хамрагдаж буй ажилтнууд багаар ажиллан, Хүүхдийн

эрх хөндөгдөж байгаа, нийгэмд тулгамдсан асуудлууд дээр санал бодлоо чөлөөтэй хуваалцлаа.

**Налайх** дүүргийн №151 гэр цэцэрлэгт ариун цэврийн байгууламж, үүдний өрөө барьж өглөө.

Ариг Банк нь 2017 онд 2 дахь удаагаа Налайх дүүргийн гэр цэцэрлэгүүдэд ариун цэврийн байгууламж болон үүдний хувцас солих өрөө барьж өгсөн. 2015 онд №152 дугаар цэцэрлэгт барьж өгсөн бөгөөд 2017 онд №151 гэр цэцэрлэгт ариун цэврийн байгууламж барьж өгсөн юм.

Налайх дүүргийн цэцэрлэгийн насны хүүхдүүдийн 40 орчим хувь нь цэцэрлэгт хамрагдаж чаддаггүй бөгөөд ЮНИСЕФ-ээс гэр цэцэрлэгүүдийг хандивласан байдаг. Гэр цэцэрлэгүүд нь төв цэцэрлэгтээ түшиглэн хүүхдүүдэд сургуулийн өмнөх боловсрол олгох үйл ажиллагаа явуулдаг бөгөөд дотроо тусдаа ариун цэврийн өрөө байхгүйн улмаас эрүүл ахуйн шаардлага хангахгүй модон жорлон болон төв цэцэрлэгийн ариун цэврийн өрөө ашигладаг байсан юм.

Иймээс хүүхдүүд бие засахаар явах замдаа даарах, өвдөх, халтирч унах зэрэг эрсдэлтэй байсныг Ариг банк харилцагчдын хамт сайхан сэтгэлийн гараа сунгаж, Налайх дүүргийн 151-р гэр цэцэрлэгийн бяцхан дүү

нар маань стандартын шаардлага хангасан ариун цэврийн өрөөтэй болж, эрүүл тухтай орчинд сурч хүмүүжих боломжтой боллоо.

Энэ жил бид банкны харилцагчиддаа сайн үйлсэд бидэнтэй нэгдэх, хувь нэмрээ оруулах боломжийг олгосон юм. Тодруулбал, бид шинээр хугацаат хадгаламж нээлгэсэн, сунгасан болон орлого хийсэн дүнгийн 100,000₮ тутамд 50₮-ийг тухайн хадгаламж эзэмшигч харилцагчийн өмнөөс Ариг Банк өөрийн санхүүгээс гаргаж, сайн үйлсийн санд хандивласан юм.







# ХАРИЛЦАГЧИЙГ ХАЛАМЖЛАХ БОДЛОГО

Ариг Банк нь харилцагчийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлж, тэдгээрийн эрх ашгийг хамгаалах ажлын хүрээнд сар бүр харилцагчийн сэтгэл ханамжийн судалгааг авч бүтээгдэхүүн, үйлчилгээндээ саналыг тусган үйл ажиллагаагаа улам бүр сайжруулсаар байна. Харилцагчиддаа зориулан дараах бодлогыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж байна.

- Хууль журмын дагуу өдөр тутмын үйл ажиллагаагаа явуулж, холбогдох тайлан мэдээ, санхүүгийн тоон үзүүлэлтүүд, хувьцаа эзэмшигч зэрэг шаардлагатай мэдээллүүдийг үнэн зөвөөр, заасан хугацаанд нийтэд ил тодоор мэдээлэх
- Харилцагийн мэдээллийн нууцыг чандлан хандгалах, эрх үүргийг холбогдох гэрээнд тодорхой тусган, энэ тухай тайлбарлахдаа мэргэжлийн үг хэллэг ашиглахгүй байх
- Харилцагчийн төлбөр тооцоог цаг алдалгүй, түргэн шуурхай дамжуулах
- Харилцагч нартаа аюулгүй үйлчилгээг хүргэн, санхүүгийн гэмт хэргээс урьчилан сэргийлэхийн тулд мэргэжлийн боловсон хүчнийг тогтмол сургах ажлыг зохион байгуулах, харилцагч нарт гарч болох эрсдэл болоод хэрхэн өөрсдийгөө хамгаалах тухай

мэдээллийг шуурхай хүргэх

- Харилцагчийн хүсэл шаардлагад нийцсэн, зах зээлийн эрэлт хэрэгцээг хангахуйц, шилдэг технологид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэн хүргэх
- Банк мэдээллийн ил тод байдлыг эрхэмлэн бүтээгдэхүүн үйлчилгээний нөхцөл, хүү шимтгэл хураамжид өөрчлөлт орсон тохиолдолд энэ талаар урьдчилан харилцагчид мэдэгдэх ажлыг дэс дараалалтай, шуурхай зохион байгуулах
- Харилцагч нарт хүргэж буй банкны үйл ажиллагаа, бүтээгдэхүүн, үйлчилгээний нөхцөл, тайлбар нь энгийн бөгөөд ойлгомжтой байхад анхаарч, мэдээллийг тогтмол үнэн зөвөөр, ил тод байршуулах
- Харилцагчийн санхүүгийн боловсролыг дэмжих зорилгоор бусад шаардлагатай сургалтыг тогтмол явуулан мэдээлэл хүргэн ажиллаж байна
- Банкны нийгмийн хариуцлагын хүрээнд олон нийтийн арга хэмжээг дэмжин ажиллах





## ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН БҮТЭЦ, ТОГТОЛЦОО

Банкны бизнес нь харилцах, хадгаламж эзэмшигчдийн мөнгөн хөрөнгийг найдвартай хадгалж, өсгөн арвижуулахаас гадна эрсдэлээс хамгаалах хариуцлагатай үүрэг хүлээдгийн хувьд Ариг Банк нь үр ашигтай эрсдэлийн удирдлагын тогтолцоог бүрдүүлэхэд анхаарч ажиллаж байна. Эрсдэлийн удирдлагын тогтолцоо нь эрсдэлийг удирдах бүх үйл ажиллагаанаас гадна түүнийг зохицуулах бодлого, журам, хэрэгжүүлэх үйл явц болон эрсдэлийн удирдлагад оролцож буй нэгж болон банкны ажилтан бүрийн үүрэг хариуцлагыг тодорхойлсон бүтэц зохион байгуулалт, эрсдэлийн мэдээллийн болон хяналтын үр ашигтай системээс бүрдэнэ.

## ЭРСДЭЛИЙН ЗАСАГЛАЛ

Эрсдэлийн удирдлагын бүтэц нь 4 түвшинд хуваагдана.

I Түвшин - Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Эрсдэлийн Удирдлагын Хороо /ТУЗ-н ЭУХ/: Эрсдэлийн удирдлагын баримтлах стратеги, бодлого болон банкны хүлээн зөвшөөрөх эрсдэлийн түвшинг батлах, тэдгээрийн хэрэгжилтийг хангуулах;

II Түвшин – Банкны Эрсдэлийн Хороо /ЭХ/ нь банкны эрсдэлийн бодлого, хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэмжээ нь банкны үндсэн үйл ажиллагаатай нийцэж байгаа эсэхэд тогтмол хяналт тавьж, түүний хэрэгжилтийг ТУЗ-ийн ЭУХ -д тайлагнах банкны гол эрсдэлүүдийг тодорхойлж, түүнийг бууруулах арга хэмжээг авах, эрсдэлийн удирдлагатай холбоотой журам зааврыг батлах, эрсдэлийн соёлыг нэвтрүүлэх, хөгжүүлэх, хэрэгжилтийг хянах үйл ажиллагааг хамаарна.

III Түвшин - Эрсдэл хариуцсан нэгжүүд: Эрсдэл цэгнэх баг, Зээл цэгнэх баг, Санхүүгийн жолоодлогын баг, Дотоод аудитын жигүүр /ДАЖ/, Эрсдэл хариуцсан нэгжүүд нь эрсдэлийн бодлого ба журмын хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих, мөн



банкны үйл ажиллагааг дэмжих болон удирдах нэгжүүд, бизнес нэгжүүдийн эрсдэлийн удирдлагад дэмжлэг үзүүлэх, эрсдэлийн удирдлагад оролцогчдыг холбох, эрсдэлийн нэгдсэн мэдээллээр хангах, банкны эрсдэлийн хорооны үйл ажиллагааг зохион байгуулах ажиллагааг хариуцна.

**IV** Түвшин - Салбарын нэгж, өргөөд нь өөрсдийн хариуцан ажиллаж буй үйл ажиллагааны хүрээнд эрсдэлийг удирдаж ажиллана.

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Банк үйл ажиллагааны эрсдэлийн хүрээнд дараах эрсдэлээс сэргийлж ажиллана. Үүнд:

- Ашиглан,
- Залилан,
- Ажлын байрны аюулгүй байдлын эрсдэл,
- Харилцагчийн эрсдэл,
- Бүтээгдэхүүн үйлчилгээний эрсдэл,
- Мэдээлэл технологийн системийн эрсдэл,

- Дотоод үйл явцын эрсдэл,
- Гадаад хүчин зүйлийн эрсдэл,
- Хуулийн болон гадны зохицуулалтад үл нийцэх эрсдэл,
- Хариуцлагын эрсдэл,
- Хөрөнгийн эрсдэл,
- Боловсон хүчний эрсдэл

Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлага нь банкны үйл ажиллагааны эрсдэлийн түвшинг тодорхойлох, эрсдэлийг үүсгэж буй хүчин зүйлийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх арга замын талаар шийдвэрүүдийг гаргаж гүйцэтгэлийг хэлэлцэн дүгнэж ажилладаг.

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРСДЭЛ

Эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа нь зээлийн эрсдэл, зах зээлийн эрсдэл, хөрвөх чадварын эрсдэл, үйл ажиллагааны эрсдэлийн үндсэн гурван чиглэлд тулгуурлан эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг хамгийн бага түвшинд байлгахад чиглэгдэж байна.

Өнгөрөгч онд банкны үйл ажиллагаанд учирч

болзошгүй эрсдэлийг бууруулах, хяналтын тогтолцооны оновчтой байдлыг үнэлэн, зөвлөмж боловсруулан холбогдох газар нэгжид хүргүүлэх замаар үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлж ажилласан.

2017 онд гэмт халдлагаас урьдчилан сэргийлэх зөвлөмжийг гарган хэрэгжүүлж, банкны мэдээллийн болон бүртгэлийн системд хандах хэрэглэгчийн эрхийн зохицуулалтыг шинэчлэн боловсруулж, хэрэглэгчийн зүй бус хандалт, хэрэглээнээс үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлж хүлээн зөвшөөрөх хамгийн бага түвшинд барьж ажиллалаа.

Мэдээлэлийн аюулгүй байдлын хүрээнд бодлого журмыг шинэчлэн баталж мэдээллийн системийн тасралтгүй, найдвартай ажиллагааг хангаж ажиллаж байна.

## ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

2017 онд Ариг Банк нь зээлийн эрсдэлийн бодлогоо нарийвчлан тодорхойлж, эдийн засгийн нөхцөл байдал, банкны богино

болон дунд хугацааны бизнес төлөвлөгөөтэй уялдуулан, зээлийн эрсдэлийн хязгааруудыг шинэчлэн өөрчилж, зээлийн эрсдэлээс сэргийлэх арга хэмжээг урьдчилан оновчтой хэрэгжүүлсэн. Банкны зээлийн эрсдэлийн удирдлагын гол зорилго нь гадаад хүчин зүйлсийн нөлөөгөөр зээлийн багцын чанар муудах мөн эдийн засгийн салбар, валют, зээлийн нэг бүтээгдэхүүнд эсвэл холбоотой бүлэг этгээдэд зээлийн хэт төвлөрөл бий болгохоос урьдчилан сэргийлэх, түүнчлэн банк эрх бүхий байгууллага болон хөрөнгө оруулагчдын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхэд оршино.

Энэхүү зорилгын хүрээнд бид зээлийн багцын чанарт үнэлгээ хийх, хүлээгдэж буй алдагдлын хэмжээг тодорхойлох, төвлөрлийн эрсдэлийг үнэлэх, хязгаарлах, нөхцөл байдлын шинжилгээ хийх зэргээр зээлийн багцын эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлж байна. Ариг Банк нь үр ашигтай эрсдэлийн удирдлагын гол үзүүлэлт болох эрсдэлийн хязгаарлалтуудыг банкны хэмжээнд, холбогдох нэгжүүдийн үйл ажиллагааны онцлог, цар хүрээг тооцоолон зохистой хэмжээнд боловсруулан баталж, хэрэгжүүлж ажилладаг. Ариг Банкны үйл ажиллагаа өргөжин тэлэхийн хэрээр зээлийг тухайн өдөрт нь бус цаг, минутын дотор шийдвэрлэх тогтолцоог бүрдүүлэх шаардлага нэмэгдсээр байна. Мөн зээлийн эрсдэлийн удирдлагыг

оновчтой хэрэгжүүлэх үүднээс банкны харилцагчийн өргөөд, Зээлийн Хороо болон Төлөөлөн Удирдах Зөвлөл зэрэг зээл шийдвэрлэх түвшин болгонд зээлийн дээд хэмжээг тодорхойлж, зээлдэгчийн зээлжих чадварыг кредит скорингийн системээр үнэлэн ажиллаж байна.

## АКТИВ, ПАССИВЫН ХОСОЛСОН УДИРДЛАГА

Тайлант онд харилцагч, хувь нийлүүлэгчийн хөрөнгийг эрсдэл багатай активт байршуулж, хөрөнгийн эрсдэлгүй, аюулгүй байдлыг чанарын өндөр түвшинд хангах зорилгоор хөрөнгө зохицуулалтын үйл ажиллагаа, бизнесийн нэгжүүдийн уялдаа холбоог сайжруулах, удирдлагын системийг боловсонгүй болгох чиглэлээр ажиллалаа. Банкны эрсдэл даах чадвар, үр өгөөжтэй ажиллагааг илэрхийлэх гол үзүүлэлт болох өөрийн хөрөнгийн хүрэлцээг Монголбанкны шалгуур үзүүлэлтийг 20%-иас дээш хадгалж, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа үзүүлэлтийг 30%-иас дээш хадгалж санхүүгийн чадавхиа бэхжүүллээ.















# DARKHAN CITY



# ULAANBAATAR CITY

# МАНАЙ ХАРИЛЦАГЧИЙН ӨРГӨӨД

Харилцагчийн Өргөөд маань Улаанбаатар болон Дархан уул аймагт байрлаж байна.

-  Хан-Уул
-  Хан-Уул Юнайтед
-  Гурвалжин
-  40 Мянгат
-  Хороолол /Алтан Төгрөг/
-  Хороолол /Номин/
-  Сонгинохайрхан
-  Баянзүрх
-  М20
-  Бөмбөгөр
-  Да Хүрээ
-  Дархан
-  Шинэ Дархан
-  Дархан Зах
-  Prestige Banking



 [arigbank.mn](http://arigbank.mn) |  7013 3060 |  arigbank